**МОНГОЛ УЛСЫН**
**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН**
**САЙДЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 09 өдөр Дугаар А/04 Улаанбаатар хот

# Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолын 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 144 дүгээр захирамжаар батлагдсан Үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр гарган танилцуулж байхыг Монгол банкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга бөгөөд Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Батбаатар)-т даалгасугай.

Х.НЯМБААТАР

15160144

Хууль зүй, дотоодын хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн A/06 дугаар тушаалын хавсралт

# МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн | Хамтран |
| **ЗОРИЛГО 1: МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОХ ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ЭРСДЭЛИЙН ОЙЛГОЛТЫГ САЙЖРУУЛАХ** | | | | | |
| **Зорилт 1.1.** Үндэсний эрсдэлийг тогтмол хянаж, мөнгө угаах, терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх аюул занал, салбарын эмзэг байдлын өөрчлөлтийг үнэлэх | 1 | Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдэлийн үнэлгээг шинэчлэгдсэн ФАТФ-ын Зөвлөмж 1-д нийцүүлэн хийх (хориг арга хэмжээнээс зайлсхийх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх эрсдэлүүдийг анхаарах) | 2023 он | ТТЗ, ТЕГ | ТТЗ-ийн бүрэлдэхүүн байгууллагууд |
| | 2 | Үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээний давтамж, хийх аргачлал, шаардлагатай санхүүжилт, урамшуулал, хамтын ажиллагааны талаарх зохицуулалтыг хууль, журамд тусгах, үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээг хийх байгууллагуудын үүргийг хуульчлах | 2023-2024 он | СМА, ХЗДХЯ, МБ | УДШ, ШЕЗ, УЕПГ, СЯ, СЗХ, АТГ, ТЕГ, ТТЗ |
| | 3 | Төлөвлөгөөний 2-т заасан ажлыг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардлагатай зохион байгуулалт, санхүүжилт, урамшуулал, үүрэг хариуцлага, хамтын ажиллагаатай холбогдох асуудлаар хүчин төгөлдөр хууль, тогтоомжийн хүрээнд Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагуудад зориулан зөвлөмж гаргах | 2023 он | ҮЗ | ХАЗ |
| | 4 | Үндэсний эрсдэлийн үнэлгээ, салбарын түвшний эрсдэлийн үнэлгээ хийх үүргийг ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагуудын ажлын чиг үүрэгт тусгах | 2023-2026 он | СМА, ХЗДХЯ, СЯ, МБ, СЗХ, ТТЗ | УЕПГ, ТЕГ, АТГ, ЦЕГ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ, ҮСХ (Үндэсний статистикийн хороо) |
| | 5 | Үндэсний эрсдэлийн үнэлгээ, салбарын түвшний эрсдэлийн үнэлгээнд хувийн хэвшил, судлаач, мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэх | Тухай бүр | ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагууд | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.2.** Тухайлсан салбар, чиглэл болон шинээр үүсэж буй стратегийн шинжтэй аюул занал, чиг хандлага, типологи, эрсдэлийн дохио /нөхцөл байдал/-г харгалзан бусад эрсдэлийг үнэлэх, шинэчлэх | 6 | Ковид-19 цар тахалтай холбоотой үүссэн МУТС эрсдэлийг судалж, холбогдох арга хэмжээг авах | 2023 он | ХАЗ-ийн дэргэдэх Судалгаа дүн шинжилгээний ажлын хэсэг | |
| | 7 | Зэрлэг ан амьтдын хууль бус худалдаа, хүрээлэн буй орчин, уул уурхайтай холбоотой мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийг судалж, холбогдох арга хэмжээг авах | 2023 он | ХАЗ-ийн дэргэдэх Судалгаа дүн шинжилгээний ажлын хэсэг | УЕПГ, ГЕГ, ЦЕГ, АТГ, ТЕГ, СМА |
| | 8 | Хуулийн этгээдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахтай холбоотой эрсдэлийн үнэлгээг шинэчлэх | 2023 он | ТатЕГ, УБЕГ, СМА | ХЗДХЯ, СЗХ, АТГ, ТЕГ, ЦЕГ, УЕПГ |
| | 9 | Траст болон компанийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх | 2023-2024 он | СЗХ | МӨХ, МХХ, ТатЕГ, УБЕГ, СМА |
| | 10 | Гэрээт нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийн үнэлгээг хийх | 2024 он | ММНБИ | ТатЕГ, СЯ |
| | 11 | Сүүлийн үед шинээр гарч ирж буй чиг хандлагыг тусгасан типологийн, стратегийн болон бусад дүн шинжилгээний тайлан гаргах | 2023-2026 он | СМА | АТГ, ЦЕГ, ТЕГ, ШЕЗ, УЕПГ |
| **Зорилт 1.3.** Салбарын болон мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийг оновчтой тодорхойлж, хяналт шалгалтын үйл ажиллагааг уялдуулах | 12 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зорилгоор МУТСТ тогтолцоонд хамаарах этгээдийн салбартай холбоотой эрсдэлийг үнэлэх | Жил бүр | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХЗДХЯ, СЯ |
| | 13 | Мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийг үнэлэх матрицыг МУТС суурь эрсдэл, эмзэг сул тал болон эрсдэлийг бууруулах арга хэмжээний үр дүнг харгалзан тухай бүр өөрчилж шинэчлэн, боловсронгуй болгох | Жил бүр | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХЗДХЯ, СЯ |
| | 14 | Мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрийн эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай тоон болон чанарын мэдээллийг цуглуулах нэгдсэн аргачлал боловсруулж хэрэгжүүлэх | Жил бүр | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХАЗ-ийн дэргэдэх Хяналт шалгалтын ажлын хэсэг |
| **Зорилт 1.4.** Үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээг харгалзан мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн үйл ажиллагааны түвшинд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх, шинэчлэх | 15 | Мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулан байгууллагын эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийж гүйцэтгэх талаарх зөвлөмж, заавар шинэчлэх | 2025-2027 он | СМА | ХАЗ-ийн дэргэдэх Хяналт шалгалтын ажлын хэсэг |
| | 16 | Мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн эсэхэд зайны болон газар дээрх хяналт шалгалтаар хяналт тавих | Жил бүр | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХАЗ-ийн дэргэдэх Хяналт шалгалтын ажлын хэсэг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.5.** Эрсдэлийн үнэлгээгээр бага эрсдэлтэй гэж тодорхойлсон үр дүнг тогтмол нягтлах, шинэчлэх | 17 | Бага эрсдэлтэй мэдээлэх үүрэгтэй этгээдийг МУТСТ үүргээс хэсэгчлэн чөлөөлөх боломжийг судлах | 2023-2024 он | СЗХ | МБ, СМА |
| | 18 | МУТСТ тухай хууль болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журамд өөрчлөлт оруулж, МУТСТ үүргээс чөлөөлөх болон хялбаршуулсан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах | 2023-2025 он | СЗХ, МБ | СМА, СЯ, ХЗДХЯ, ТЕГ |
| **Зорилт 1.6.** Мөнгө угаах, терроризм болон зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны статистик мэдээлэл гаргах, нэгтгэх ажлыг ФАТФ-ын стандартад нийцүүлэх | 19 | ФАТФ-ын зөвлөмж болон шууд хэрэгжилттэй холбоотой, зайлшгүй гаргах шаардлагатай статистик мэдээллийн жагсаалт гаргах | 2023 он | ХАЗ-ийн дэргэдэх Судалгаа дүн шинжилгээний ажлын хэсэг | СМА |
| | 20 | Шаардлагатай статистик мэдээллийг гаргахтай холбогдуулан хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах, статистик мэдээлэл гаргах маягтыг батлуулах, холбогдох байгууллагад хүргүүлж, статистик мэдээллийг үнэн зөв бүрэн гаргах боломжийг бүрдүүлж ажиллах | 2023 он | СМА, ҮСХ | ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагууд |
| | 21 | Зөрчлийн нэгдсэн мэдээллийн санг МУТСТ чиглэлээр хөгжүүлэлт хийх, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх | 2023-2025 он | УЕПГ | МБ, СМА, СЗХ, АТГ, ТЕГ, ЦЕГ, ТатЕГ, ГЕГ, УБЕГ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ |
| **ЗОРИЛГО 2: МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА, ЭРСДЭЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ** | | | | | |
| **Зорилт 2.1.** Үндэсний эрсдэлийн үнэлгээ, бусад эрсдэлийн үнэлгээний үр дүнг мэдээлэх үүрэгтэй этгээд болон холбогдох байгууллагуудад таниулах | 22 | ҮЭҮ болон салбарын эрсдэлийн үнэлгээний тайлан, гарсан үр дүнг мэдээлэх үүрэгтэй этгээд, мэргэжлийн холбоод болон эрх бүхий бусад байгууллагад танилцуулах төлөвлөгөө боловсруулж, батлах | 2023-2030 он | СМА, МБ, СЗХ, ТТЗ | ХЗДХЯ, СЯ, УЕПГ, ТЕГ, АТГ, ЦЕГ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ |
| | 23 | Батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу ҮЭҮ болон салбарын эрсдэлийн үнэлгээний тайлан, гарсан үр дүнг танилцуулах сургалт, сурталчилгааны ажлууд зохион байгуулах | 2023-2030 он | СМА, МБ, СЗХ, ТТЗ | ХЗДХЯ, СЯ, УЕПГ, ТЕГ, АТГ, ЦЕГ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ |
| **Зорилт 2.2.** Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэх | 24 | Мэдээлэх үүрэгтэй этгээдийн комплаенсийн ажилтнуудын МУТСТ үүрэг, хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, зорилтот түвшинд хүргэх сургалт, сурталчилгааны ажлууд зохион байгуулах | Жил бүр | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | СМА, ХЗДХЯ, СЯ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 25 | Мэдээлэх үүрэгтэй этгээдэд МУТСТ хууль тогтоомжид орсон өөрчлөлт, шинэчлэлтийн талаар тухай бүр танилцуулж байх | Жил бүр | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХЗДХЯ, СЯ, СМА, ХАЗ-ийн Хууль, эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэг |
| | 26 | Мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан мэдлэг дээшлүүлэх болон чадавхыг сайжруулах үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлох, түүний дагуу төлөвлөгөө гаргаж холбогдох ажлуудыг зохион байгуулах | Жил бүр | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХЗДХЯ, СЯ, СМА, МБХ, ЦЕГ, АТГ, ТЕГ, ТТЗ |
| | 27 | ФАТФ-аас зөвлөсний дагуу улирал бүр МУТСТ/ҮОХЗДСТ тогтолцооны дутагдалтай улсуудын талаарх мэдээллийг Мэдээлэх үүрэгтэй этгээдэд хүргүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаардах | Жил бүр | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ, СМА | ХЗДХЯ, СЯ |
| **Зорилт 2.3.** Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг хариуцлагын талаарх ойлголт, мэдлэг олгох | 28 | ВХҮҮ-д МУТС/ҮОХЗДС-тэй холбогдох эрсдэл, хүлээх үүрэг хариуцлага, мэдээлэх үүргийг таниулах, ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх | Жил бүр | СЗХ | СМА, ТТЗ, ТЕГ, АТГ, ЦЕГ |
| | 29 | ВХҮҮ-д зориулан МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг хариуцлага болон бүртгүүлэхэд тавигдах шаардлагын талаарх мэдээлэл бүхий гарын авлага, заавар зөвлөмж гаргаж хүргүүлэх | Жил бүр | СЗХ | СМА, ТТЗ, ТЕГ, АТГ, ЦЕГ, ТатЕГ |
| **Зорилт 2.4.** Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх | 30 | МУТСТ тухай нэгдсэн мэдээллийн цахим хуудсыг хөгжүүлэх, шинэ мэдээ, мэдээлэл тогтмол оруулах | 2023-2030 он | СМА | ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагууд, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ |
| | 31 | МУТСТ тогтолцоог энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарласан цахим контент, хэвлэмэл товхимол бэлтгэж гаргах, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлууд зохион байгуулах | 2023-2030 он | ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагууд | ММНБИ, МНТ, МӨХ, МХХ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 32 | Оюутан, судлаачдыг МУТСТ чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвихад уриалж сэдэлжүүлэх, дэмжих, бодлогын шийдвэр гаргалтад оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | 2023-2030 он | СМА | ХАЗ-ийн дэргэдэх 5 ажлын хэсэг |
| | 33 | Харилцагчид мэдээлэх үүрэгтэй этгээдээр үйлчлүүлэх үед бичиг баримт, эцсийн өмчлөгчийн мэдээлэл болон холбогдох бусад мэдээллийг гаргаж өгөхтэй холбоотой тавигдах хуулийн шаардлага болон данс, бүтээгдэхүүн, үйлчилгээний МУТС зорилгоор ашиглагдах болзошгүй эрсдэлийн талаар олон нийтэд мэдээлэл өгч, соён гэгээрүүлэх компанит ажил өрнүүлэх | 2023-2030 он | МБ, СЗХ, СМА, ХЗДХЯ, СЯ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | МҮЭ |
| **ЗОРИЛГО 3: МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ДОТООД БОЛОН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ** | | | | | |
| **Зорилт 3.1.** Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл, ажлын хэсгүүдийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх аюул занал, эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлогын болон үйл ажиллагааны түвшинд дотоод хамтын ажиллагааг бэхжүүлэх | 34 | ҮЗ-ийн хурлаар Монгол Улсын МУТС, ҮОХЗДС-тэй тэмцэх үндэсний хөтөлбөр шинээр үүсч буй аюул занал болон эрсдэлийн талаар хэлэлцэж, бодлогын арга хэмжээг авч байх | Жил бүр | ҮЗ | ХАЗ |
| | 35 | ХАЗ-ийн хурлаар МУТС, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэл, шинээр үүсч буй аюул занал болон эрсдэлийг бууруулах, удирдах ажлыг үйл ажиллагааны түвшинд зохион байгуулах | Жил бүр | ХАЗ | - |
| | 36 | Санхүүгийн хүртээмж болон МУТСТ ажлыг уялдуулан зохион байгуулах, санхүүгийн хүртээмжтэй холбоотой асуудлыг ХАЗ-ийн хурлаар хэлэлцдэг байх | Жил бүр | МБ, СЗХ, СМА, СЯ, ХЗДХЯ | - |
| | 37 | ХАЗ-ийн дэргэдэх ажлын хэсгүүдийн ажиллах процедурыг тодорхой болгох, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих талаар журамд тодорхой тусгах | 2023 он | ХАЗ | ХАЗ-ийн дэргэдэх ажлын хэсгүүд |
| | 38 | ФАТФ-ын хориг арга хэмжээ авах орнуудын жагсаалтад орсон улстай холбоотой НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолуудыг хэрэгжүүлэх зорилгоор ҮОХЗДС-тэй тэмцэх ажлыг зохицуулах уулзалтыг тогтмол зохион байгуулах | 2023-2030 | ТТЗ, ТЕГ, ГХЯ | МБ, СМА, ТЕГ, СЯ, ХЗДХЯ, СЗХ, ШЕЗ, УЕПГ, ТТЗ, АТГ, ЦЕГ, УБЕГ, ТатЕГ, ГЕГ |
| | 39 | Мэдээлэл солилцох системийг боловсронгуй болгох, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, цаасан мэдээллийн солилцооны тогтолцоог халах, эргэх холбоог (feedback mechanism) бий болгох, мэдээлэл солилцох олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх | 2023-2024 он | СМА, ТЕГ, АТГ, ЦЕГ, УЕПГ | МБ, СМА, СЯ, ХЗДХЯ, СЗХ, ШЕЗ, ГХЯ, ТТЗ, УБЕГ, ТатЕГ, ГЕГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 40 | УБЕГ эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулахтай холбоотой арга хэмжээг авах, эрх бүхий байгууллагууд энэ мэдээлэлд шууд хандах ажлыг эрчимжүүлэх | 2023-2024 он | УБЕГ, ХЗДХЯ | МБ, СМА, ТЕГ, СЗХ, ШЕЗ, УЕПГ, ГХЯ, ТТЗ, АТГ, ЦЕГ, ТатЕГ, ГЕГ |
| | 41 | Зохицуулагч байгууллагууд мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайлан, үр дүн, нийтлэг зөрчил, дутагдал, чиг хандлага болон типологийн талаар уулзаж хэлэлцэх, | 2023-2030 | МБ, СЗХ, ХЗДХЯ, СЯ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХСМА | УЕПГ |
| **Зорилт 3.2**. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих | 42 | ХАЗ-ийн дэргэдэх ажлын хэсгүүдэд мэдээлэх үүрэгтэй этгээд, мэргэжлийн холбоодын төлөөллийг орон тооны бус гишүүнээр оролцуулж, хамтын ажиллагаа, эргэх холбоог сайжруулах | 2023-2026 он | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ, ТТЗ, СМА, ТЕГ, ЦЕГ, АТГ | СЯ, ХЗДХЯ, ШЕЗ, УЕПГ, ГХЯ, ТТЗ, УБЕГ, ТатЕГ, ГЕГ |
| | 43 | Санхүүгийн мэдээллийн “Финтел” холбоог байгуулсан бусад улс орнуудын сайн туршлагыг судлах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 2023 он | СМА | МБХ, ХАЗ-ийн Судалгаа дүн шинжилгээний ажлын хэсэг |
| **Зорилт 3.3.** Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого тодорхойлох, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх | 44 | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон улсын донор байгууллагуудтай техник туслалцаа, чадавхыг бэхжүүлэх хүрээнд хамтран ажиллах боломжийг судлах, холбогдох арга хэмжээг авах | 2023-2030 он | ХАЗ-ийн гишүүн байгууллагууд | - |
| **Зорилт 3.4.** Мэдээлэл солилцох болон хууль сахиулах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх | 45 | Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах чиглэлээр мөрдөгдөж буй гадаад хамтын ажиллагааны эрх зүйн баримт бичгийг үнэлж, сайжруулах, мэдээлэл солилцох болон хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох | 2023-2026 он | ЦЕГ, АТГ, ТЕГ | СМА, ГХЯ, ТатЕГ, ГЕГ |
| | 46 | Гадаад улсын хууль сахиулах байгууллага болон СМА-тай мэдээлэл солилцох хамтын ажиллагааны гэрээ, хэлцэл, харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэх, сайжруулах | 2023-2026 он | ТЕГ, ЦЕГ, АТГ, СМА | ХЗДХЯ, ГХЯ, МБ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3.5.** Дотоод болон гадаад улсын эрх бүхий байгууллагатай түргэн шуурхай мэдээлэл солилцох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах | 47 | Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг солилцох чиглэлээр гадаад хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг олон улсын стандартад нийцүүлэх, мэдээлэл түргэн шуурхай солилцох арга замыг тодорхойлох | 2023-2024 он | ХЗДХЯ, УЕПГ | УБЕГ, ГХЯ, АТГ, ТЕГ, ЦЕГ |
| **Зорилт 3.6.** Олон улсын болон гадаад улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагатай хамтын ажиллагаагаа бий болгох, өргөжүүлэх | 48 | ҮЭҮ болон холбогдох мэдээлэлд үндэслэсэн хяналт шалгалтын чиглэлээрх гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах | 2023-2030 он | СЗХ, МБ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ, СМА | СЯ, ХЗДХЯ |
| | 49 | Хяналт шалгалтын чиглэлээр ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаад улсын байгууллагуудтай санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, олон улсын байгууллагад гишүүнээр элсэх зэргээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, хяналт шалгалтын зорилгоор мэдээлэл солилцож хамтран ажиллах | 2023-2030 он | СЗХ, МБ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ, СМА | ГХЯ, ХЗДХЯ, СЯ |
| | 50 | Санхүүгийн байгууллага нь гадаад улсын хуулийн этгээдийн охин компани, салбар, гадаад улсын санхүүгийн байгууллагын толгой компани бол тухайн улсын хяналт шалгалтын байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах | 2023-2026 он | МБ, СЗХ | СМА |
| | 51 | Хяналт шалгалтын зорилгоор мэдээллийг солилцох, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамтран ажиллах гэрээ, хэлцэл байгуулах хууль, эрх зүйн орчныг тодорхой болгох, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, журам, заавар гаргах | 2023-2030 он | СЗХ, МБ, ХЗДХЯ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ, СМА | СЯ, ГХЯ, Хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэг |
| **Зорилт 3.7.** Мөнгө угаах, түүний суурь гэмт хэргийг мөрдөн шалгах, хөрөнгө буцаах чиглэлээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг үр дүнтэй, түргэн шуурхай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх | 52 | Үндэстэн дамнасан гэмт хэргийн нөхцөл байдал болон ҮЭҮ-ний үр дүнд үндэслэн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхтэй холбоотой тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, холбогдох арга хэмжээг авах | 2023-2030 он | УЕПГ | ХЗДХЯ, ГХЯ, ТЕГ, АТГ, ЦЕГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 53 | Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбоотой олон улсын олон талт гэрээ, конвенцид нэгдэн орох талаар судалж, шийдвэрлэх | 2023-2030 он | ХЗДХЯ, ГХЯ, УЕПГ | ЦЕГ, АТГ, ТЕГ |
| | 54 | Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг сайжруулах, олон улсын стандартад нийцүүлэх | 2023-2030 он | ХЗДХЯ, УЕПГ, ТЕГ, ЦЕГ, АТГ | ГХЯ, Хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэг |
| | 55 | Гадаад улсад байгаа хүнээс гэрчийн мэдүүлгийг зайнаас, цахимаар авах болон хөрөнгө буцаах ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх зорилгоор дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох | 2024-2028 он | ХЗДХЯ | УЕПГ, ТЕГ, АТГ, ЦЕГ |
| | 56 | Эрх зүйн туслалцааг харилцан үзүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр хуулийн болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх | Жил бүр | УДШ, УЕПГ | ХЗДХЯ, ГХЯ, ШЕЗ, АТГ, ТЕГ, ЦЕГ |
| | 57 | Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхтэй холбоотой гарын авлага гаргах | 2023 он | УЕПГ | ХЗДХЯ, АТГ, ТЕГ, ЦЕГ |
| | 58 | Эрх бүхий байгууллагууд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхтэй холбоотой дундын "Цахим мэдээллийн нэгдсэн сан"-г бий болгох | 2023-2025 он | ХЗДХЯ, ГХЯ, УЕПГ | СЯ, АТГ, ТЕГ, ЦЕГ |
| | 59 | Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд ажиллах мэргэшсэн орчуулагчийг сонгон шалгаруулахтай холбогдох зохицуулалтыг нарийвчлан тодорхой болгох | 2023-2024 он | ХЗДХЯ, УЕПГ | АТГ, ТЕГ, ЦЕГ |
| **ЗОРИЛГО 4: МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛД СУУРИЛСАН БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | |
| **Зорилт 4.1.** Эрсдэлийн үнэлгээ, хөтөлбөрийн хэрэгжилт, бусад нөхцөл байдалд үндэслэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг шинэчлэх | 60 | МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн ажлын төлөвлөгөөг эрсдэлийн нөхцөл байдалтай нь уялдуулан шинэчилж байх, хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнах | 2023-2030 он | Үндэсний зөвлөл | МБ, СМА, ТЕГ, СЯ, ХЗДХЯ, СЗХ, УДШ, НЭХДЗШШ, ШЕЗ, УЕПГ, ГХЯ, ТТЗ, АТГ, ЦЕГ, УБЕГ, ТатЕГ, ГЕГ |
| | 61 | Терроризмтой тэмцэх үндэсний хөтөлбөрийг Үндэсний МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх хөтөлбөр, стратегийн өөрчлөлт, шинэчлэлтэй | 2023 он | ТТЗ | ХЗДХЯ, СЯ, ТЕГ, МБ, СЗХ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4.2.** Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн байгууллагын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгаж хэрэгжүүлэх | 62 | Байгууллагууд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон салбарын эрсдэлийн үнэлгээний үр дүн, МУТС-тэй тэмцэх хөтөлбөрийн төлөвлөгөөний арга хэмжээг тусгаж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | 2023-2030 он | МБ, СМА, ТЕГ, СЯ, ХЗДХЯ, СЗХ, ШЕЗ, УЕПГ, ГХЯ, ТТЗ, АТГ, ЦЕГ, УБЕГ, ТатЕГ, ГЕГ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | - |
| **Зорилт 4.3.** Мөнгө угаах болон өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, холбогдох хөрөнгө хураахад чиглэсэн аргачлал, заавар, зөвлөмж гаргах, шинэчлэх | 63 | Мөнгө угаах болон Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, хөрөнгө хураах, зэрэгцээ мөрдөн шалгалт явуулах чиглэлээр аргачлал боловсруулах | 2023-2030 он | УЕПГ, ЦЕГ, АТГ, ТЕГ | ХЗДХЯ, УДШ |
| **Зорилт 4.4.** Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн болон мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийн хувийн хэрэгт үндэслэн хяналт шалгалтын стратегийг | 64 | ҮЭҮ болон салбарын эрсдэлийн үнэлгээний үр дүнг хяналт шалгалтын стратеги, төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх | 2023-2026 он | СЗХ, МБ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ, СМА | ХЗДХЯ, СЯ, ТТЗ |
| | 65 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын стратеги шинэчилж, хэрэгжүүлэхтэй холбогдуулан ФАТФ-аас гаргасан аргачлал, заавар зөвлөмж болон бусад улс, орны сайн туршлагыг судалж нэвтрүүлэх | 2023-2030 он | СЗХ, МБ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | СМА, ХЗДХЯ, СЯ, ТТЗ |
| **Зорилт 4.5.** Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хянан шалгахдаа эрсдэлд суурилсан дотоод хяналтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих | 66 | Мэдээлэх үүрэгтэй этгээд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан бодлого, журам хэрэгжүүлж байгаа эсэхэд зайнаас болон газар дээрх хяналт шалгалт хийж, хяналт тавих | Жил бүр | СЗХ, МБ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | СМА, ХЗДХЯ, СЯ |
| **Зорилт 4.6.** Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх | 67 | Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлэх . | 2023-2030 он | СЗХ | ХАЗ-ийн дэргэдэх Хяналт шалгалтын ажлын хэсэг |
| | 68 | ВХҮҮ-ийн үйл ажиллагаанд блокчейн хяналтын програмыг нэвтрүүлэх | 2023-2023 он | СЗХ | СЯ, ХАЗ-ийн дэргэдэх Хяналт шалгалтын ажлын хэсэг |
| **ЗОРИЛГО 5. МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭД ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОХООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5.1.** Монгол Улсын Харилцан үнэлгээний тайлан, Явцын тайланд дурдсан техник хэрэгжилтийн дутагдлыг арилгах, ФАТФ-ын Зөвлөмжид орсон өөрчлөлтийг тусгах зорилгоор дотоодын хууль тогтоомжийг шинэчлэх | 69 | Тэтгэврийн сан, даатгалын сангуудын МУТС эрсдэлийг үнэлэх | 2023-2024 он | СЗХ, СЯ | МБ, СМА, ТЕГ, ХЗДХЯ, ТТЗ, АТГ, УБЕГ, ТатЕГ |
| | 70 | Банкнаас бусад санхүүгийн байгууллагын удирдлага, эцсийн өмчлөгч, түүнтэй холбоотой этгээдэд тавигдах шаардлагыг бүрэн тодорхойлж, гэмт этгээд болон түүний холбоотон мэдээлэх үүрэгтэй этгээдийн удирдлагад байхаас сэргийлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах, түүнийг нягталж, шалгах тогтолцоог бүрдүүлэх | 2023-2026 он | СЗХ, ХЗДХЯ | СМА, ТЕГ, СЯ |
| | 71 | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулж, мэдээлэх үүрэгтэй этгээд үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагыг нэмж тусгах | 2023-2024 он | МБ, СЗХ, ХЗДХЯ | СМА, ТЕГ, СЯ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ |
| | 72 | Корреспондент банк, цахим шилжүүлэг болон гуравдагч этгээдийг ашиглахтай холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор санхүүгийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог хөгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нэвтрүүлэх талаар судлах | 2023 он | Мэргэжлийн холбоод | МБ, СЗХ, ХАЗ-ийн дэргэдэх Судалгаа дүн шинжилгээний ажлын хэсэг |
| | 73 | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд тус тус өөрчлөлт оруулж, эцсийн өмчлөгчийг тогтоох хувийг 33-аас 25 хувь болгож бууруулах | 2023-2024 он | МБ | ХЗДХЯ, ТЕГ, СЯ, СЗХ, СМА |
| | 74 | МУТС хуулийг ФАТФ зөвлөмж 10.2-той нийцүүлэх | 2023-2024 он | СЗХ, МБ | СМА, ХЗДХЯ |
| | 75 | ТС/ҮОХЗДС тэмцэх зорилгоор ашгийн бус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, гаргасан зөрчил, дутагдалд арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлэх | 2023-2024 он | ТатЕГ, ТЕГ | ХЗДХЯ, СМА, ТТЗ, УБЕГ |
| **Зорилт 5.2.** Тохиромжтой этгээдийн шалгуурын үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох | 76 | Мэдээлэх үүрэгтэй этгээдийн удирдлага, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нь гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдэж байсан нь мэдэгдсэн тохиолдолд түүний бүртгэлийг цуцлах, түдгэлзүүлэх эсхүл хасах арга хэмжээг авах | 2023-2030 он | СЗХ, МБ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ШЕЗ, ЦЕГ |
| | 77 | Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэгчийн МУТС эрсдэлийг нарийвчлан судалж, эрсдэлд суурилсан арга хэмжээг авах, МҮЭ болгох эсэхийг шийдвэрлэх | 2023-2025 он | СЗХ | СЯ, ХЗДХЯ, УБЕГ, ТатЕГ, СМА |
| | 78 | ҮМҮЧЭТХЭАЭ болон ҮХЭХЗБ-ын салбарын зохицуулалтын хуулийн төслийг боловсруулж эрх бүхий этгээдэд танилцуулах | 2025-2028 он | СЗХ | ХЗДХЯ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 79 | Тусгай зөвшөөрөлгүй, бүртгэлгүй цахим төлбөр тооцоо, мөнгө гуйвуулгын үйлчилгээ, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг илрүүлэх, мэдээлэл солилцох чиглэлээр ХСБ-уудтай дөрвөлсөн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах | 2023-2023 он | СЗХ, ТЕГ, ЦЕГ, СМА | ТЕГ |
| | 80 | Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй ҮМҮЧЭТХЭАЭ болон ҮХЭХЗБ-д хариуцлага тооцох эрх зүйн орчныг боловсронгуй болгох | 2025-2028 он | СЗХ | ХЗДХЯ |
| | 81 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.14, 3.1.15 дахь заалтыг өөрчлөн найруулах | 2024-2026 он | СЯ, ММНБИ | ХЗДХЯ |
| | 82 | Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх, үйл ажиллагааг эрх бүхий байгууллагад тайлагнах эрх зүйн орчинг сайжруулах | 2024 он | МХХ, МӨХ | ХЗДХЯ |
| | 83 | Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох | 2024 он | МХХ, МӨХ | ХЗДХЯ |
| **Зорилт 5.3.** Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнтэй байдлыг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох | 84 | ҮМҮЧЭТХЭАЭ-ийг 20 сая төгрөгөөс дээш дүнтэй арилжааг бэлэн мөнгөөр хийхийг хууль тогтоомжоор хориглох | 2025-2028 он | СЗХ | ХЗДХЯ |
| | 85 | Банкууд өөрийн эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үзсэн харилцагчтай хийх бизнесийн харилцааг түдгэлзүүлэх, харилцаагаа таслах хүртэл арга хэмжээ авах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх | 2023-2024 он | МБХ | МБ, СМА, ХЗДХЯ |
| | 86 | Гүйлгээний үнийн дүнтэй уялдуулан гүйлгээний утга, зориулалтыг үнэн зөв мэдүүлэхийг үүрэгжүүлэх | 2023-2024 он | СМА, МБ | ХЗДХЯ |
| | 87 | Зайнаас харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийх боломжийг судлах, олон улсын стандартад нийцтэйгээр зохицуулах | 2023-2024 он | СМА, МБ, СЗХ, ХЗДХЯ | ММНБИ, МНТ, МӨХ, МХХ |
| | 88 | МУТСТ тухай хуулийн 19.1-д нэмэлт, өөрчлөлт оруулж, СББМҮҮ-дэд хяналт тавих эрх бүхий байгууллагын эрх зүйн байдлыг тодорхой болгох | 2023-2024 он | СМА, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ, ХЗДХЯ | ХАЗ-ийн гишүүн байгууллагууд |
| **Зорилт 5.4.** Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын давтамж, чанарыг сайжруулах, зөрчилд тохирсон хариуцлагын арга хэмжээ авах | 89 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журмуудыг шинэчлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох | 2023-2024 он | МБ, СЗХ, СМА, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХЗДХЯ, СЯ |
| | 90 | Мэдээлэх үүрэгтэй этгээд тайлан, мэдээллийг цахимаар тайлагнах үйл явцыг боловсронгуй болгож, цуглуулсан мэдээллийг боловсруулж үнэлэх хяналт шалгалтын технологийг /Suptech/ нэвтрүүлэх | 2023-2026 он | МБ, СЗХ, СМА, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХЗДХЯ, СЯ |
| | 91 | Эрсдэлийн үнэлгээ, зайны болон газар дээрх хяналт шалгалтын үр дүн болон бусад мэдээлэлд үндэслэн мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийн зэрэглэл, зайн болон газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөг тухай бүр шинэчлэн батлах, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх | Жил бүр | МБ, СЗХ, СМА, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХЗДХЯ, СЯ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 104 | NFT арилжааны платформуудын зохицуулалтын орчин, бодлогыг тодорхойлох | 2023-2024 он | СЗХ | ВХҮҮ-ийн Мэргэжлийн холбоо, СМА |
| | 105 | ВХҮҮ-ийн МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хариуцлагын арга хэмжээ авах | 2023-2026 он | СЗХ | АТГ, ЦЕГ, ТЕГ |
| **Зорилт 5.6.** Мэдээлэх үүрэгтэй этгээдийн комплаенсийн ажилтнуудын чиг үүргээ хэрэгжүүлэх эрх мэдлийг нэмэгдүүлэх | 106 | Комплаенсийн нэгж, ажилтнууд удирдлагаас хараат бус байж, үүргээ шударгаар биелүүлж, үйл ажиллагаагаа хувьцаа эзэмшигчид болон төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж байгаа эсэхэд хяналт тавих | 2023-2026 он | МБ, СЗХ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ | ХЗДХЯ, СЯ |
| | 107 | Комплаенсийн нэгж, ажилтнууд удирдлагаас хараат бус байж, үүргээ биелүүлэх, тавигдах шаардлагын хууль эрх зүйн орчинг сайжруулах | 2023-2026 он | СМА, ХЗДХЯ | Мэргэжлийн холбоод, МБ, СЗХ, СЯ, ММНБИ, МНТ, МӨХ, МХХ |
